



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/642

Арвайхээр

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 13 дугаар баг Т.Намнансүрэнгийн 3 дугаар гудамж 307 тоотын хойно 1935 м² газрыг Арвайхээр сумын 13 дугаар цэцэрлэг (РД:3553094)-т боловсролын байгууллагын зориулалтаар, 13 дугаар баг Т.Намансүрэнгийн 3 дугаар гудамж 307 тоотод 10831 м² газрыг Арвайхээр сумын ерөнхий боловсролын Тэмүүлэл-Эрдэм сургууль (РД:8320179)-д боловсролын байгууллагын зориулалтаар тус тус 40 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2009 оны 235 дугаар захирамжийн Цэцэрлэг-бага сургуультай холбогдох заалт, 2019 оны А/422 дугаар захирамжийн Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газарт холбогдох заалт, 2019 оны А/544 дүгээр захирамжийн хавсралтын Арвайхээр сумын ерөнхий боловсролын Тэмүүлэл-Эрдэм сургуультай холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Дээрх газар эзэмших эрх авсан хуулийн этгээдтэй газар эзэмших гэрээг байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101199